


**МОНИНЖБАР ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Манай компани 1956 онд Нийгэм ахуйн барилгын газар нэртэйгээр байгуулагдсан ба 1981 онд Нийтийн аж ахуйн техник туслалцааны барилгыг удирдах ерөнхий газар болон өөрчлөгдсөн ,1992 оноос Монгол улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийгэм ахуйн барилгын МОНИНЖБАР Хувьцаат компани нэртэйгээр ажил үйлчилгээ явуулж байна.

Тус компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хот хөдөөгийн иргэний болон нийтийн аж ахуйн чиглэлийн барилга байгууламжууд, халаалтын зуух, дулааны болон цэвэр, бохир усны шугамын барилга угсралт, автозам, усан сан, насосны станцын байгууламж, үерийн болон хамгаалалтын далан зэрэг хот, нийтийн төвлөрсөн инженерийн байгууламж барьдаг мэргэжлийн байгууллага болж боловсон хүчин, техник хэрэгслээр бүрэн бэхжиж хангагдсан юм.

Хагас зуун жилийн дотор МОНИНЖБАР ХК нь Монгол улсын бүх аймаг, Нийслэл Улаанбаатар хотод нийт 1000 гаруй том жижиг барилга байгууламжуудыг барьж байгуулсан. Сүүлийн жилүүдэд Монгол улсын засгийн газрын болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн байгууллагууд, мөн бусад хандивлагч орнуудын санхүүжилттэй томоохон төслүүдэд хувь нэмрээ оруулж байна. Сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн томоохон ажлуудаас дурдвал:

- \* ТЭЦ-III-ийн захиалгаар станцын үнсэн сангийн далан, шугам сүлжээний өргөтгөл
- \* МУ-ын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар Мах комбинат, Талх-Чихрийн үйлдвэрийн үерийн хамгаалалтын далан,
- \* Дэнжийн 1000 айл орчмын үерийн хамгаалалтын далан,
- \* Өмнөтийн районы усан хангамжийн Ф500 мм-ийн цэвэр усны шугам,
- \* Гадаадын зээл тусламжийн хүрээнд 3-р цахилгаан станцын зуухан цехийн трубины яндангийн дулаалга тусгаарлалтын ажил,
- \* МУ-ын Засгийн газрын хөрөнгө оруулалттай Хасбаатарын гудамжны хатуу хучилттай замын борооны ус зайлуулах шугам,
- \* Бохир усны 8-р коллекторын шугам,
- \* Ард Аюушийн өргөн чөлөөний борооны ус зайлуулах Ф1000 мм-ийн шугам,
- \* Багануурын орон сууцны барилгын бохирын шугам,
- \* Хөтөлийн цэвэрлэх байгууламжийн лагийн талбайн өргөтгөл
- \* Өмнөговийн Даланзадгадын ДЦС-ын цэвэр бохир усны шугам, гүний худгууд, усан сангийн барилга,
- \* Оддын хотхоны орон сууцны барилга
- \* Москва хороололд орон сууцны барилгын шугам сүлжээ,
- \* Хан'Уул дүүрэгт үйлдвэрийн байр
- \* Орон сууцны барилгын дотор сантехник болон цахилгааны ажлууд
- \* Дэлхийн банкны гэр хорооллын НАА-г сайжруулах төслийн гүйцэтгэгч
- \* Уул уурхай компаниудын үйлдвэр, цехийн болон агуулахын барилгууд
- \* Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгийн хүрээнд хэрэгжиж байгаа Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн Мөрөн.



Улиастай хотуудад инженерийн байгууламж, НАА-н чиглэлийн цогцолбор барилга байгууламжууд

- \* Дэлхийн банкны зээлийн хүрээнд хэрэгжиж байгаа Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийн Хайлааст, Яармагийн 500, 1500м<sup>3</sup>-ийн багтаамжтай усан сангийн барилгууд
- \* Солонгосын HYUNDAI корпорацийн зээлийн хөрөнгөөр баригдаж байгаа Өмнөговийн ДЦС-ийн гадна дулаан, хэрэглээний халуун усны шугамын ажлууд зэргийг ашиглалтад хүлээлгэн өгсөн.
- \* Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр Тасган-Зүүн хойд бүсийн усан сангийн холбоос Ф500мм голч бүхий зөөлөн ширмэн яндан угсралтын ажил
- \* 4-р цахилгаан станцын шинэ үнсэн сангийн 4-р секцийн газар шорооны ажил, шугам хоолой, шандорын худгийн хамт иж бүрэн барилга байгууламжууд,
- \* Хятадын засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд "Ахмадууд ба төрийн ажилтны орон сууцны төсөл

Манай компани одоо Азийн хөгжлийн банкны "Орон сууцны санхүүжилт" төслийн хүрээнд Дарь-Эхийн гэр хороололд баригдах АОС-ны хорооллын гадна цэвэр бохир усны шугамын эхний ээлжийн ажилд туслан гүйцэтгэгчээр, 2-р шатны ажлын цэвэр усны шугамыг ерөнхий гүйцэтгэгчээр хэрэгжүүлж байна.


Тус компанийн гадаадын хамтын ажиллагааны түншүүд:

- \* Италийн ABB компаний туслан гүйцэтгэгчээр ажиллан ТЭЦ-3-ийн цахилгаан станцын өргөтгөлийн трубины хоолойн дулаалга, тусгаарлалт дээр
- \* Канадын GOLDEN TIGER компанитай хамтран Заамарын алтны уурхайн шороон байгууламж дээр
- \* Японы DAI NIPPON компаний туслан гүйцэтгэгчээр ажиллан цэвэр усны төв станцын тоног төхөөрмжийн өргөтгөл, суурилуулалтын ажил дээр
- \* Мөн Японы DAI NIPPON компаний туслан гүйцэтгэгчээр ажиллан
- \* БНСУ-ын Дэеву корпораци Ханвуу групп, Гоовел, Даелим групп
- \* БНХАУ-ын Гуди, Шандоны барилгын болон хүнд механизмын компани, үйлдвэрүүд байдаг нь бидний бахархал юм.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Хүний нөөцийн ажилтан

 Б.Мөнхбат



**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ**

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХАРИУЛТ
1.	Оноосон нэр	МОНИНЖБАР
2.	Улсын бүртгэлийн дугаар	2061287
3.	Гэрчилгээний дугаар /регистр/	35/3014
4.	Тусгай зөвшөөрлийн дугаар	БУ 20-15/03
5.	Өмчийн хэлбэр	Хувьцаат компани
6.	Оршин буй хаяг	Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, бага тойруу 24/3, 5дугаар хороо
7.	Шуудангийн хайрцаг, e-mail хаяг, харилцах утас, факс	Улаанбаатар –46 <a href="mailto:moneng@magicnet.mn">moneng@magicnet.mn</a> tel: 976-11-319322 Fax:976-11-311585 976-11-327000
8.	Эрхэлдэг ажлын үндсэн чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>- цахилгаан дамжуулах дэд станц угсрах</li> <li>- цэвэр усны байгууламж барих</li> <li>- усан хангамж, ариутгах татуургын инженерийн барилгы байгууламж, шугам сүлжээ угсралт</li> <li>- авто граж, ил зогсоол ажиллуулах</li> <li>- Худалдаа</li> </ul>
9.	Харьяалагдах татварын албаны нэр	Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс
10.	Үйлчлүүлэгч банкны нэр	Худалдаа Хөгжил банк Анод банк Голомт банк Улаанбаатар банк
11.	Байгуулагдсан он	1956 оны 11 сарын 24

БҮРТГЭВ. 04  
 Бүртгэл хяналтын  
 Алба  
 126

**Нийтэд санал болгон үнэт цаасны зах зээл дээр худалдахаар компаниас гаргасан үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл**


		Бүртгэлийн асуулга	Үзүүлэлт	
0	А		Б	
01	Үнэт цаас гаргагчийн	Нэр	Монинжбар Хувьцаат компани	
		Оршинбайх газар, хаяг	Чингэлтэй дүүрэг Бага тойруу 24/3	
		Өмчийн хэлбэр	Хувьцаат	
		Эрхэлж буй үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл	Барилга, инженерийн шугам сүлжээ	
		Гүйцэтгэх захирлын овог нэр	Дондов Мөнхбаатар	
		Ерөнхий нягтлан бодогч, / санхүү эрхэлсэн захирал /-ийн овог нэр	Баянжаргал Баярсайхан	
		Улсын бүртгэлийн	Бүртгэлийн дугаар Регистрийн дугаар	35/3014 2061287
		Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхэлдэг бол	Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн нэр	БУ 3.1.1, 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.5, 3.3.3
			Дугаар	БУ19-00043/06
			Олгосон огноо	2006.03.30
	Зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын нэр		Барига, Хот Байгуулалтын ЯАМ	
02	Гаргагчид үнэт цаас	Төрөл	Энгийн хувьцаа	
		Нэр		
		Тоо, ширхэг	10 000 000	
		Нэг бүрийн нэрлэсэн үнэ	100 төг	
		Үнийн дүн	1 000 000 000	
		Өрийн бичиг гаргасан бол эргэн төлөгдөх хугацаа, хүү		
03	Зөвшөөрөгдсөн үнэт цаас гаргасан	Бүртгэлийн дугаар		
		Регистрийн дугаар		
		Код		
04	Бүртгэсэн огноо			

Бүртгэсэн: Хорооны бүртгэлийн мэргэжилтэн / /

Хянаж зөвшөөрсөн: БСХО-ын хэлтсийн дарга / /

Баталсан: Албаны дарга / /

/ тэмдэг /



Хувьцаа арилжаалагдсанаар төвлөрөх мөнгөн хөрөнгө,  
түүнийг зарцуулах тайлан, үр ашигийн тооцоо

**1. Төвлөрөх мөнгөн хөрөнгө**

10 000 000 ширхэг энгийн хувьцааг нийтэд арилжжалснаар компани  
1 000 000 000 төгрөг төвлөрөх боломжтой.

**2. Зарцуулалт**


- 2006 онд гүйцэтгэж байгаа болон 2007 онд гүйцэтгэх гэрээт ажлуудыг цаг хугацаанд нь таслатгүй явуулж чанарын өндөр түвшинд улсын комист хүлээлгэн өгөхөд 300 000 000 сая төгрөгийг тодорхой хувиарийн дагуу санхүүжүүлэх.

2006 оны 09 сар	50 000 000 төгрөг
2006 оны 10 сар	40 000 000 төгрөг
2006 оны 11 сар	40 000 000 төгрөг
2007 оны 04 сар	20 000 000 төгрөг
2007 оны 05 сар	20 000 000 төгрөг
2007 оны 06 сар	50 000 000 төгрөг
2007 оны 07 сар	60 000 000 төгрөг
2007 оны 08 сар	20 000 000 төгрөг
Нийт	<b>300 000 000 төгрөг</b>

2006-2007 оны барилгын ажлын явцад урд нь гүйцэтгэсэн, гүйцэтгэж байгаа ажлуудын санхүүжилтүүд гүйцэтгэлээрээ санхүүжигдэн хөрөнгө төвлөрсөн байх тул хувьцаанаас орж ирэх хөрөнгөөр нэн түрүүнд санхүүжүүлэх шаардлагагүй гэж үзэж болно.

2006 оны 09 сар	80 000 000 төг
2006 оны 10 сар	120 000 000 төг
2006 оны 11 сар	50 000 000 төг
2006 оны 12 сар	40 000 000 төг
2006 оны 06 сар	100 000 000 төг
2006 оны 07 сар	180 000 000 төг
2006 оны 08 сар	150 000 000 төг
2006 оны 09 сар	200 000 000 төг
2006 оны 10 сар	200 000 000 төг
2006 оны 11 сар	300 000 000 төг
2006 оны 12 сар	112 000 000 төг
Нийт	<b>1 532 800 000 төг</b>

Тухайн хийгдэж байгаа санхүүжилт нь зөвхөн 2006 онд хийгдсэн гэрээт ажлуудын санхүүжилт бөгөөд 2007-2008 оны барилгын улиралд манай компани 2.0 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.



Дэлхийн банк, АХБанк, Хандивлагч орнууд болон улсын төсөвөөр санхүүжигдэж байгаа барилга угсралтын ажлын гүйцэтгэчийг шалгаруулах сонгон шалгаруулалт олон шалтгаанаас болж цаг хугацааны хувьд хойшлогдох, санхүүжилт хийгдэхгүй удаашрах зэрэг хүндрэлтэй тохиолдолууд олон гардаг бөгөөд энэ бүгдээс шалтгаалан манай төлөвлөгөөнд өөрчлөлт орох тал байдаг.

Санхүүжилтийн графикайг хувьцааны борлуулалт, уг ажлын байршил, материалын болон гүйцэтгэлийн чанарын өндөр түвшин, санхүүжүүлж байгаа байгууллагын санхүүжилт цаг хугацаандаа хийгдэх зэргийг харгалзан цаг тухайд нь өөрчлөх боломжтой.

- 2006 оны 02 сарын 07-ны өдөр болсон бүх гишүүдийн хурлаар компанийн техник технологт парк шинэчлэл хийх, зарим шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж хувьцаанаас төвлөрөх хөрөнгөөс 700 000 000 сая төгрөгийг зарцуулахыг ТУЗ, Гүйцэтгэх захиралд зөвшөөрсний дагуу судалгаа хийсний үндсэн дээр доорхи хэрэгцээтэй байгаа техник тоног төхөөрөмжүүдийг санхүүгийн аль ашигтай хэлбэрээр худалдан авахаар шийдвэрлэсэн.

Техник тоног төхөөрөмжийг худалдан авахдаа санхүүгийн лизингийн түрээсийн хэлбэрийг сонгох бололцоотой бөгөөд дорхи хүснэгтэд урьдчилгаа төлбөр болон төлөгдөх хүүгийн хэмжээг хамтад нь бодсон болно. Зарим үнэ багатай тоног төхөөрөмжийг шууд худалдан авахаар бодож бусад гэсэн хэсэгт оруулсан.


Марк	Тоо	Худалдан авах үнэ	Гааль, НӨТ	Бүгд
Камаз 3511	3	105 000 \$	23 600 \$	128 600 \$
Бульдозер / дундаж ханш /	2	120 000 \$	27 000 \$	147 000 \$
Грейдэр	1	32 000 \$	7 200 \$	39 200 \$
Авто ачигч	2	79 000 \$	17 775 \$	96 775 \$
Индуу	2	43 500 \$	9 787 \$	53 287 \$
Бусад тоног төхөөрөмж				128 000 \$
Дүн				592 262 \$

$592\ 262\ \$ \times 1\ 180 = 698\ 869\ 160$  төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна.

Техник технологийн шинэчлэлт хийснээр манай компани барилга угсралтын ажилд зарцуулагдаж байгаа зардлыг 20 хүртэл хувь хэмнэх бололцоотой бөгөөд энэ нь сүүлийн үед манай зах зээлд нэвтэрч байгаа техник технологийн давуу талуудаас харагдаж байна.

2006 онд компани Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк, хандивлагч орнууд болон улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төслүүдэд амжилттай оролцож өөрийн хүчин чадалыг бүрэн дүүрэн ашиглаж ажиллахад гол анхаарлаа хандуулж ажиллавал тайлант жилд 1 тэрбум 700 орчим сая төгрөгийн борлуулалт хийж 300 орчим сая төгрөгийн ашигтай ажиллах бололцоотой юм.

Компани өөрсдийн үндсэн үйл ажиллагаанаас гадна тодорхой хугацаанд ашиглагдахгүй байгаа уул уурхай болон бусад тоног төхөөрөмж.



өөрийн байранд албан байгууллага, хувь хүмүүст ажлын байр түрээслэх, бусад үйл ажиллагаанаас жилд 100 орчим сая төгрөгийн орлого олдог.

Компанийн үндсэн бус үйл ажиллагаанаас олох орлого

	Үйл ажиллагаа	Орлого / төг /	Зардал /төг/	Ашиг / төг /
1	Байрны түрээсээр	42 000 000	12 000 000	30 000 000
2	Техник технологийн түрээс	60 000 000	9 000 000	28 000 000
3	Бусад	10 000 000		10 000 000
3	Нийт	112 000 000	21 000 000	91 000 000

Техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр графикт ажлыг хугацаанаас нь өмнө хүлээлгэн өгөх боломжтой бөгөөд ингэснээр дараа дараагийн гүйцэтгэх ажилд цаг алдалгүй орж борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.


Техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр гүйцэтгэж байгаа ажлын ертгийг бууруулах шатахуун зарцуулалтыг хэмнэх гараар гүйцэтгэж байгаа ажлыг техникээр гүйцэтгэж зардлыг хэмнэх боломжтой болох бөгөөд ингэснээр ашгийг нэмэгдүүлэх бололцоотой болох юм.

2006 онд компани нь дунджаар 1.7-2.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Монинжбар ХК-ийн 2006 онд гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлын төсөв.

/ мян.төг /

	Объектын нэр	Төсөвт өртөг	Санхүүжигдсэн	Санхүүжигдэх
1	Орхон-Хөтөлийн цэвэр усны шугамын болон өргөлтийн насосын технологийн шинэчлэлтийн ажил	1 108 000.9	62 000.0	984 000.9
2	Толгойт голын үерийн хамгаалалтын далангын байгууламжын ажил	254 000.0	49 000.0	205 000.0
3	Дархан –Уул аймгийн "Оюуны ирээдүй" цогцолбор сургуулийн их засварын ажил	188 800.0	000.0	188 800.0
4	Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Дэлгэрэх голын 12 метр урттай гүүрийн шинэчлэлтийн ажил	65 900.0	28 000.0	37 900.0
5	Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 573 метр урттай 6.0 метр өргөн хатуу хучилттай замын ажил	60 000.0	30 000.0	30 000.0
6	Дарь –Эхийн гэр хорооллын цэвэр усны шугамын ажилын 2-р шар	69 000.0	50 000.0	19 000.0




Жич: Тус компани нь 2006.07.31-ны өдөр ИНЕГ-аас зарласан Өмнөговь аймагт шинээр баригдаж байгаа нисэх буудлын үерийн хамгаалалтын далан суваг барих ажлын сонгон шалгаруулалтад оролцсон. Тухайн тендэрт оролцсон компаниудын үнийн санал, ажлын туршлага болон бусад сонгон шалгаруулалтад нөлөөлдөг үзүүлэлтүүдээс харахад манай компани шалгарах магадлал хамгийн өндөртэй байгаа юм.

	Оролцогч	Үнийн санал / төг /	Үнийн саналаар
1	Монгол Тэнжин зам ХХК	449 997 000	3
2	Номгон Хайрхан ХХК	438 550 000	2
3	МОНИНЖБАР ХК	427 347 000	1
4	Ганцаг ХХК	466 358 000	5
5	Аваргас ХХК	457 836 000	4

Тус компанийн үйл ажиллагаа явуулж байгаа зах зээл нь олон жилийн дундажаар 25-30 хувийн ашигтай ажлладаг бөгөөд энэ нь гүйцэтгэж байгаа ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэх, байгалийн гэнэтийн гамшиг, мэргэжлийн боловсон хүчин, ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжөөс, ажиллах хүчний байршил, зохион байгуулалт болон хүчин зүйлүүдээс шалтгаалан 5-10 хувийн эрсдэлийг дагуулж байдаг.

2006 онд гүйцэтгэх барилга угсралтын ажлын зардал, ашигт ажиллагааны түвшин

	Объектын нэр	Төсөвт өртөг	Зардал	Бусад зардал	Үлдэх ашиг
1	Орхон-Хөтөлийн цэвэр усны шугамын болон өргөлтийн насосын технологийн шинэчлэлтийн ажил	1 108 000.9	775 606.3	55 400.0	276 994.6
2	Толгойт голын үерийн хамгаалалтын далангын байгууламжын ажил	254 000.0	177 800.0	12 700.0	63 500.0
3	Дархан –Уул аймгийн “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн их засварын ажил	188 800.0	132 160.0	9 440.0	47 200.0






4	Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Дэлгэрэх голын 12 метр урттай гүүрийн шинэчлэлтийн ажил	65 900.0	44 030.0	3 295.0	18 575.0
5	Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод 573 метр урттай 6.0 метр өргөн хатуу хучилттай замын ажил	60 000.0	42 000.0	3 000.0	15 000.0
6	Дарь-Эхийн гэр хорооллын цэвэр усны шугамын ажлын 2-р шар	69 000.0	48 300.0	3 450.0	17 250.0
	Нийт	1 745 800.0	1 222 060.0	87 290.0	436 450.0

Компанийн үндсэн бус үйл ажиллагаанаас олох орлого

	Үйл ажиллагаа	Орлого	Зардал	Үлдэх
1	Байрны түрээсээр	42 000	12 000	30 000
2	Техник технологийн түрээс	37 000	9 000	28 000
3	Бусад	10 000		10 000
3		89 000	21 000	58 000

Эндээс харахад компани 2006 онд 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 500 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тооцож байна. 10 хувийн эрсдэлийг тооцож үзвэл 450 сая төгрөг борлуулалтын дараах ашиг болох нь.

Тооцоо хийсэн: СЭЗХэлтэсийн захирал

 Б.Баярсайхан

